


**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 8/4

Бөхт

Г Унэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.9, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх “Ерөнхий боловсролын сургуулийн гадна хашаа хийх ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Унэлгээний хорооны дарга Д.Номин-Эрдэнэ (Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч)

Гишүүд Б.Амгаланжаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)
Ө.Бямбажаргал (Иргэний төлөөлөл)
О.Амгалантөр (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга М.Цэвэгдорж (Бөхт багийн Засаг дарга)

2. Хууль тогтоомжид заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Д.Номин-Эрдэнэ)-д, архивын нэгж үүсгэн баримтжуулж ажиллахыг нарийн бичгийн дарга (М.Цэвэгдорж)-д даалгасугай.

3. Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханганд, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллахыг үнэлгээний хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

У.АЛТАНХҮҮ